



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 08 сарын 15

Дугаар 06

Улаанбаатар хот

Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдлыг сайжруулах, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг хүrtээмжтэй, шуурхай хүргэх, төрийн бүх шатны эрүүл мэндийн байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах зорилгоор гамшгаас хамгаалах эрүүл мэндийн аймаг, нийслэлийн албаны дарга, бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт ДААЛГАХ нь:

Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдлыг сайжруулах, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг хүrtээмжтэй, шуурхай хүргэх, төрийн бүх шатны эрүүл мэндийн байгууллагад ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгах зорилгоор гамшгаас хамгаалах эрүүл мэндийн аймаг, нийслэлийн албаны дарга, бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт ДААЛГАХ нь:

1. Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн орон нутгийн албаны төлөвлөгөө, байгууллагын гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, батлагдсан төлөвлөгөөний 1 хувийг Эмнэлгийн тусlamжийн газарт 2018 оны 08 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх;
2. Үер, бусад болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр гамшгаас хамгаалах орон нутгийн албадын бэлтгэл бэлэн байдал (автомашин, техник хэрэгсэл, шатахуун, хүн хүчиний томилгоо, эмнэлгийн тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц)-ыг хангаж ажиллах;
3. Эрүүл мэндийн байгууллагууд гамшгийн эрсдлийн үнэлгээг холбогдох мэргэжлийн байгууллагаар хийлгэж, зохих арга хэмжээг урьдчилан авч хэрэгжүүлэх;
4. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын мэдээллийг Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт шуурхай мэдээлэх;
5. Халдварт өвчний дэгдэлтийн бэлэн байдлын нөөц, нөхөн хангальт хийх, үерийн дараа гарч болзошгүй гэдэсний халдварт өвчний дэгдэлтээс сэргийлэх үйл ажиллагаанд харьяалах нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагыг нийгмийн хариуцлагын хүрээнд татан оролцуулж халдвартайжүүлэх ажлыг зохион байгуулах, ундны усыг хлоржуулах;

6. Үй олныг хамарсан осол гэмтлийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, эмнэлгийн яаралтай тусlamжийн бэлэн байдлыг сайжруулах, гамшигийн үеийн эмнэлгийн тусlamжийн багийг чадавхжуулах;

7. Үерийн гамшигийн үеийн нийгмийн сэтгэл зүйд тохирсон мэдээлэл, сургалт, сурталчилгааг олон нийтийн хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээгээр идэвхтэй зохион байгуулах, үерийн гамшигт нэрвэгдэгсдэд сэтгэл зүйн дэижлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх;

8. 2017-2018 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөний биелэлт болон 2018-2019 оны өвөлжилтийн судалгаа /хүн амын судалгаа, тулгамдсан асуудал, цаашид шийдвэрлүүлэх асуудал/, 2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын батлагдсан төлөвлөгөөг Эмнэлгийн тусlamжийн газарт 08 дугаар сарын 20-ны дотор ирүүлэх;

9. Төрийн бүх шатны эрүүл мэндийн байгууллагын албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, ажлын цаг ашиглалтыг чанд сахих, ажлын байранд архидан согтуурахгүй байх, төрийн албаны стандартыг хатуу баримтлах;

10. Албан даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээ, гарсан үр дүнгийн тайланг заалт бүрээр гаргаж 09 дүгээр сарын 10-ны дотор тус яамны Эмнэлгийн тусlamжийн газарт ирүүлэх.

Хавсралт: 2 хуудастай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД БӨГӨӨД ГАМШГААС  
ХАМГААЛАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН УЛСЫН  
АЛБАНЫ ДАРГА

Д.САРАНГЭРЭЛ

